

БАТЛАВ. АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.ИЧИНХОРЛОО

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

Сүмбэр сумын 5-р сургуулийн 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдлийн аудит : *ШХ*

2. Аудитын код: /УАГ-ГСБ-/2015/-03-ЭА/

3. Аудит хийх үндэслэл:

Аймгийн ИТХ-ын захиалга, Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилго:

Сүмбэр сумын 5-р сургуулийн 2014 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, үр өгөөжийг дээшлүүлэх талаар зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэхэд оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудын хүрээнд асуудлыг авч үзнэ. Үүнд:

- Байгууллагын төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- Ажиллагсдын цалин, хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бодож олгосон эсэх
- Ажиллагсдын үр дүнгийн урамшууллыг зохих журмын дагуу үнэн зөв дүгнэж олгосон эсэх

5. Аудитын хамрах хүрээ:

Сүмбэр сумын 5-р сургуулийн 2014 оны батлагдсан төсөв, санхүүгийн баримт, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт материалыг хамруулан аудитыг гүйцэтгэнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Сүмбэр сумын 5-р сургууль нь сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн бие даасан бүтээлч үйл ажиллагааг дэмжих замаар багш, хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2013 онд тус сургуульд 784,935.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжилтээ бүрэн авч, түрээсийн орлого 400.0 мянга, нэмэлт санхүүжилт 14,977.0 мянга, нийт 800,312.2 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 784,982.1 мянган төгрөгийг зарцуулж, түрээсийн орлогыг ОНӨАлбанд, төсвийн хэмнэлт 14,930.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

2014 онд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны зардалд 931,461.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, аймгийн шилдэг сургуулиар шалгарч шагнал урамшуулалд 3,300.0 мянга, 2013 оны төсвийн урамшуулал 500.0 мянга, мэргэжил дээшүүлэх зардлын санхүүжилт 747.3 мянга, нийт 936,008.6 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэртэй ажилласан байна. Үүнээс: урсгал зардлын хэмнэлт 1170.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

7. Эрсдлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, өмнө хийгдэж байсан гүйцэтгэлийн аудитын дүн, 2013-2014 онуудын санхүүгийн аудитын тайлан, байгууллагын судалгаа болон харилцан ярилцлагад үндэслэн байгууллагын ерөнхий эрсдлийг "дунд" гэж үнэлэв.

Эрсдэл	Магадлал	Үр дагавар	Үнэлгээ
Байгууллагын эрсдэл			
Байгууллагын өөрийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байх	бага	бага	бага
Үйл ажиллагааны эрсдэл			
Батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулаагүй байх	бага	бага	Бага
Ажиллагсдын цалин хөлсийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу бодож олгоогүй байх	дунд	дунд	дунд
Ажиллагсдын цалингаас суутгах суутгалуудыг үнэн зөв суутгаж, цаг хугацаанд нь шилжүүлээгүй байх	дунд	дунд	дунд
Ажиллагсдын үр дүнгийн урамшууллыг зохих журмын дагуу үнэлж олгоогүй байх	дунд	дунд	дунд
Цалин хөлсийг НДШ-ийн болон ХХОАТ-ын татварын тайланд үнэн зөв тайлагнаагүй байх	бага	дунд	дунд
Хөндлөнгийн эрсдэл			

Ажиллагсдаас цалин хөлсний холбогдолтой өргөдөл гомдол гарсан байх	бага	дунд	Дунд
Төсвийг үндэслэлгүй баталж ажиллагсдын цалин хугацаандаа олгогдоогүй байх	бага	дунд	дунд
Эрсдлийн ерөнхий үнэлгээ	бага	дунд	дунд

Эрсдэлийн үнэлгээ

Магадал	Үр дагавар	
Бага	5	2
Дунд	3	6
Их	0	0

8. Аудитын арга зүй

Аудитад Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэл, Нийцлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглаж, байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тулган баталгаажуулалт, харьцуулалт, зэрэгцүүлэлт, асуудлын шинжилгээ, үдшийн цайллага зэрэг аудитын арга зүйг мөрдөж ажиллана.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт

Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, Төрийн аудитын тухай хууль,НББ-ийн тухай хууль, Төрийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад холбогдох хууль эрх зүйн актуудыг шалгуур болгон ашиглана.

10.Аудитын хугацаа

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2015 оны 03 сарын 27-ноос 03 дугаар сарын 30 нийг хүртэл, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 02 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

11.Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо хянан удирдаж, ахлах аудитор Ц.Батсайхан, шинжээч Э.Гансүх нар гүйцэтгэнэ.

12.Аудитын тайлангийн бүтэц

Аудитын тайлан нь аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, аудитаас бий болсон үр өгөөж, аудитын зөвлөмж, хавсралтуудаас бүрдэнэ. Аудитын тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулна.

13.Аудитын үр өгөөж

Аудитын үр өгөөжийг Монгол улсын ерөнхий аудиторовн 2007 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Аудитын үр өгөөжийг төлөвлөх ,бүртгэх, тайлагнах, хянах, мэдээлэх журам"-ын дагуу бүртгэнэ.

14.Аудитад ашиглагдах хөрөнгө, нөөц

- Боловсон хүчин: 3 хүн, 7өдөр, 21 хүн өдөр
- Санхүүгийн нөөц: 2,400.0 мянган төгрөг
- Техник хэрэгсэл: компьютер, диктафон, фото аппарат болон бусад техник хэрэгсэл

Аудитын төлөвлөгөө боловсруулсан :

Ахлах аудитор  Ц.Батсайхан

2015 оны 03 дугаар сарын 27